

ТАВАНТОЛГОЙ ХК
ОМНОГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 01

Цогцэний сум

**“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны
болон санхүүгийн тайланг танилцуулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.4 дэх хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.9 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн дэлгэрэнгүй тайланг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад зохих мэдээллийг Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд журмын дагуу хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 02

Цогцлэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн
гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.9 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 16, 17 дугаар тогтоолоор батлагдсан “Тавантолгой” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.

2.Хуралд танилцуулсан дүгнэлтийг цаашид бодлого, шийдвэртээ тусгаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 03

Цогтцэний сум

“Тавантолгой” ХК-ийн 2025 оны цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах
зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.13, Долоогийн 7.4.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 07, 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 тоот тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн 2025 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдэд бүрэн олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА




Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 04

Цогтгэний сум

**Тавантолгой” ХК-ийн 2024 оны цэвэр
ашгаас ногдол ашиг хуваарилсан
тайланг танилцуулах тухай**

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.15 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.13, Долоогийн 7.4.11 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1.“Тавантолгой” ХК-ийн 2024 оны жилийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахтай холбоотойгоор 2025 оны тайлант жилд гүйцэтгэсэн ногдол ашиг тараах үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2.Ногдол ашиг хуваарилан олгосон тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 05

Цогтгэний сум

**“Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах
зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны
тайланг танилцуулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсныг тэмдэглэсүгэй.

2. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлант жилийн хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааг **ХАНГАЛТТАЙ** гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 09 сарын 27 өдөр

Дутаар 06

Цогтгүний сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон
хараат бус гишүүнийг сонгох тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.2, 77.4 дэх хэсэг, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.9, 6.14.7 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн, хараат бус гишүүдийг Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг кумулятив аргаар тоолж нэгтгэсэн дүнд үндэслэн дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

- 1.1. Бямбаагийн Мэндбаяр /ердийн гишүүн/
- 1.2. Эрдэнэчулууны Бөхбат /ердийн гишүүн/
- 1.3. Ёндонгийн Номинтунгалаг /ердийн гишүүн/
- 1.4. Дашдэмбэрэлийн Бат-Эрдэнэ /ердийн гишүүн/
- 1.5. Сүрэнхүүгийн Мятавдорж /ердийн гишүүн/
- 1.6. Цэнд-Аюушийн Цэнгэлбаяр /ердийн гишүүн/
- 1.7. Чинзоригийн Отгонбаяр /хараат бус гишүүн/
- 1.8. Батцэцэгийн Батсүрэн /хараат бус гишүүн/
- 1.9. Даваажавын Дэлгэрцогт /хараат бус гишүүн/

2. Шинээр сонгогдсон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх, үүргийн хүрээнд идэвх санаачилгатай ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДБАЯР

ТАВАНТОЛГОЙ ХК
ӨМНӨГОВЬ АЙМАГ
“ТАВАНТОЛГОЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 07

Цогтцэций сум

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
зардлын төсвийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, “Тавантолгой” Хувьцаат компанийн дүрмийн Хоёрын 2.3 дахь хэсэг, Зургаагийн 6.14.12, 6.14.13 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 13 дугаар тогтоол, Тооллогын комиссын 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Тавантолгой” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнгийн урамшууллын хэмжээг нэгдүгээр, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөх цалингийн хэмжээг хоёрдугаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны үйл ажиллагааны төсвийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороо, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт тусгагдсан зардлыг санхүүжүүлж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА




Б.МЭНДБАЯР